


ERP СИСТЕМИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН МОДУЛЬ

ШИНЭ БАРААНЫ ХҮСЭЛТ БҮРТГЭХ БОЛОН ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХЭД **АНХААРАХ ЗҮЙЛС**

Сургалт, дэмжлэгийн баг

ШИНЭ БАРАА БҮРТГЭХ ХҮСЭЛТЭД БҮРТГЭЛ ХИЙХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

1. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтаас хайлтын багажийг ашиглан өөрт шаардлагатай шүүлт, бүлэглэлтийг хийн ашиглах боломжтой.



Зураг 1. Хайлтын багаж ашиглах

- Зөвшөөрсөн-баталгаажуулалт нь дуусаж бараа болж барааны каталогт орсон
- My request- сонгох үед миний оруулсан барааны хүсэлтүүд харагдана.
- Other requests- бусдын оруулсан барааны хүсэлтийг шүүж харах
- By Department -сонгох үед барааны нийт хүсэлтийг бүтцийн нэгжээр бүлэглэн харах боломжтой.
- By UNSPSC-сонгох үед барааны ангиллын кодоор харах
- By created user- барааны хүсэлтийг үүсгэсэн хүнээр бүлэглэн харах боломжтой
- Өөриймшүүлсэн шүүлтүүрээр үүсгэсэн шүүлтээ хадгалж авах боломжтой

2. Захиалагч өөрийн оруулсан шинэ барааны хүсэлтээ ямар төлөвтэй байгааг харах.

Төлөв	Нэр	Бренд	Загвар	Бүтцийн нэгж	Үүсгэн	Approval state	Баталгаажуулалт	Сүүлд зассан
Ноорог	Телефон аппарат тоом Unify OpenStage...	Unify	OpenStage 15 T	Холбоо, мэдээллийн технологи, автома...	М.Мөнхбаяр	Administrator дараах ажиллагаа	Үйлдвэрлэл, техникийн хэлтэс	Бүтцийн нэгж
Хянасан	Кабель утас Унн RVP 3x0.5	RVP	3x0.5	Холбоо, мэдээллийн технологи, автома...	Д.Очирбат	Баталгаажуулсан Ц.Чинзориг	Үйлдвэрлэл, техникийн хэлтэс	Үүсгэсэн
Хянасан	Цахилгаан тэнхээ баригчийн сүлжээни...	Eaton	INDON-4/2	Холбоо, мэдээллийн технологи, автома...	П.Няцагдорж	Баталгаажуулсан Ц.Чинзориг	Чиглэл харуулсан бүтцийн нэгж Мэд...	Баталгаажуулалт
Ноорог	Телефон аппарат IP Unify Openstage 40...	Unify	Openstage 40 HFA	Холбоо, мэдээллийн технологи, автома...	М.Мөнхбаяр	Баталгаажуулсан Ц.Чинзориг	Чиглэл харуулсан бүтцийн нэгж Мэд...	Бүртгэсэн огноо
Хянасан	Компьютерийн хулгана - Эргономик Logitec...	Logitech	MX Vertical	Холбоо, мэдээллийн технологи, автома...	Т.Бадралнай	Баталгаажуулсан Б.Гансэрээт	Чиглэл харуулсан бүтцийн нэгж Мэд...	Сүүлд зассан
Хянасан	Компьютерийн гар - Эргономик Logitec...	Logitech	ERGO K860 Wireless split	Холбоо, мэдээллийн технологи, автома...	Т.Бадралнай	Баталгаажуулсан Т.Бат-Ариун	Чиглэл харуулсан бүтцийн нэгж Мэд...	Сүүлд зассан
Хувирах байх	Агаарын урсгал хэмжигч Sierra SteelMa...	Sierra	SteelMass 640s	Холбоо, мэдээллийн технологи, автома...	П.Няцагдорж	Started by П.Няцагдорж	Чиглэл харуулсан бүтцийн нэгж Мэд...	Сүүлд зассан
Ноорог	Телефон аппарат аналог	Gigaset	DA710	Холбоо, мэдээллийн технологи, автома...	М.Мөнхбаяр	Баталгаажуулсан М.Мөнхбаяр	Чиглэл харуулсан бүтцийн нэгж Мэд...	Сүүлд зассан
Хянасан	Чихлэн Logitech H540	Logitech	H540	Холбоо, мэдээллийн технологи, автома...	Т.Бадралнай	Баталгаажуулсан Б.Гансэрээт	Чиглэл харуулсан бүтцийн нэгж Мэд...	Сүүлд зассан

Зураг 2. Хайлтын багаж ашиглах

Төлөв баганад:

- Ноорог – төлөв таны оруулсан шинэ барааны хүсэлт эхлүүлэх товч дараагүй байх үед харагдана
- Хүлээгдэж байна- төлөв нь эхлүүлэх товч дарж хяналтын шатанд илгээгдсэн шинэ барааны хүсэлт
- Хянасан-хяналт баталгаажуулалтын шатанд орсон барааны хүсэлтийн төлөв

Approval state:

➤ Хэн хамгийн сүүлд ямар үйлдэл хийсэн мэдээлэл харагдана


3. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн ерөнхий мэдээллийн цонх Заавал оруулах талбарууд улаанаар харагдаж байна

Зураг 8. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн ерөнхий мэдээллийн цонх Заавал оруулах талбарууд улаанаар харагдаж байна.

Анхааруулга: Хэрэглэгч та Эдийн дугаарыг оруулахад барааны ERA ангилал өөрөө сонгогдон гарч ирэх боломжтой. Хэрэв эдийн дугаар аваагүй шинэ бараа бол тухайн бараа аль ангилалд байхыг сонгож оруулна.


ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ЭРХ БҮХИЙ ХЭРЭГЛЭГЧИЙН АНХААРАХ ЗҮЙЛС

1. Тухайн хэрэглэгчийн хяналт, баталгаажуулалт хийх шаардлагатай хүсэлтийн жагсаалтыг хайлтын багажийн Шүүлтүүр хэсгээс “Needs me Review” сонгон шүүлт хийн харах боломжтой.



Зураг 3. Баталгаажуулалт хийсэн болон шаардлагатай хүсэлтүүдийн жагсаалтыг хайлтын багаж ашиглан харах

- Хяналт тавихдаа тухайн барааны ерөнхий мэдээлэл хэсэгт захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгчээс оруулсан UNSPSC ангилал, брэнд, модель, ERA ангилал, хөрөнгийн төрөл зэрэг үзүүлэлтүүд зөв орсон эсэх дээр хяналт тавьж ажиллана.
2. Захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгчээс оруулсан техникийн үзүүлэлт тус бүрд заасан UNSPSC ангиллыг чиглэл хариуцсан бүтцийн нэгж хяналт тавих үедээ барааны ангиллын түвшин ахиулан өөрчилж болно.




Зураг 4. Тухайн техникийн үзүүлэлтийг өөрчлөх болон түвшин ахиулж хадгалах

Анхааруулга: Хэрэглэгчээс оруулсан барааны ерөнхий мэдээлэл дээр байгаа бараанд уясан UNSPSC ангиллыг хяналтын бүтцийн нэгж хяналт тавих үедээ UNSPSC ангиллыг өөрчилбөл тухайн захиалагчийн оруулсан **Статик** төлөвтэй техникийн үзүүлэлт үлдэнэ бусад чиглэл хариуцсан бүтцийн нэгжээс оруулсан техникийн үзүүлэлт устах эрсдэлтэй.

Ангилал ахиулан авахдаа захиалагч бүтцийн нэгжийн оруулсан Статик төлөвтэй орсон **Үзүүлэлтийн төрлийг** заавал өөрчилж хадгална.

Захиалагчаас оруулсан төрөл нь **Статик** төрөлтэй байгааг өөрчилж **Шаардлагатай, Санал болгох, Шаардахгүй** гэсэн төрлүүдийн аль нэгнээр сольж оруулна.

- **Шаардлагатай** - төлөв нь захиалагч шинэ барааны хүсэлт илгээхдээ энэ үзүүлэлтийн утгыг заавал бөглөх ёстой ба устгах боломжгүй байна.
- **Санал болгох** - төлөв нь тухайн захиалагч үзүүлэлт дээр оруулж ч болно оруулахгүй ч байж ч болно
- **Шаардахгүй** - төлөв нь захиалагч утга оруулахгүй байж болно.



Зураг 5. Тухайн техникийн үзүүлэлтийг өөрчлөх болон үзүүлэлтийн төрөл өөрчилж хадгалах

Мэдээлэл: Үзүүлэлтийн төрлийн Статик төрөл нь зөвхөн тухайн бараан дээрээ хадгалагдана.

Анхааруулга: Хэрэглэгч та хэмжих хязгаар 0-100 техникийн үзүүлэлтийг

хэмжих доод хязгаар	0
хэмжих дээд хязгаар	100

гэж дээд доод утга болгон салгаж оруулна.

Жишээ нь: Урт * Өргөн * Өндөр гэсэн 150 x 200 x 50 үзүүлэлтийг

Өргөн: 150 см,

Өргөн: 200,


Өндөр: 50,

гэж салгаж нэг нэг үзүүлэлт болгон оруулна.

Тухайн ангилалд хамаарах техникийн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж, дараалал, нэмэлт тайлбар, нөхцөл, хайж болох талбар болон үзүүлэлтийн төрлийг оруулж өгснөөр захиалагч бүтцийн нэгж тухайн шинэ бараа бүртгэх хүсэлт гаргах үед чиглэл хариуцсан бүтцийн нэгжээс оруулсан техникийн үзүүлэлтүүд нь автоматаар татагдан орж ирнэ.


Захиалагч эдгээр үзүүлэлтүүдийн дагуу зөвхөн өөрт шаардлагатай утгыг оруулж барааны хүсэлтээ хялбар илгээх боломжийг бүрдүүлэх юм.

3. Эхлэх товч дарахад дараа Мэдээллийн цонх гарсан тохиолдолд тухайн 60131416 ангилалд чиглэл хариуцсан бүтцийн нэгж байхгүй тухай мэдэгдэл юм. Иймд хэрэглэгч та сургалт дэмжлэгийн багийн мэргэжилтэнтэй холбогдон ангиллыг нэмж бүртгүүлнэ.



Зураг 6. Мэдэгдлийн анхааруулах цонх

4. Тухайн буцаасан бараа руу дарж ороход буцаасан тайлбар доор нь харагдана.



Зураг 7. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн буцаасан тайлбар


Хэрэглэгч та мэргэжилтний тайлбарын дагуу засвараа оруулаад дахин эхлүүлэх товч дарж эхлүүлнэ.



Зураг 8. Хяналтын шатанд илгээгдсэн төлөв

Тус хүсэлтийг үүсгэсэн захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгч өөрийн зүгээс дахин боловсруулалт хийн өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд Дахин эхлүүлэх товчийг дарж, шинэ бараа бүртгэх хүсэлтийг Ноорог төлөвт шилжүүлж болно.


- Оруулсан бүлгийн нэр болон техникийн үзүүлэлтээ мөрний урд байрлах листийн тэмдэгт дээр хулганаар дарж шаардлагатай байрлалд чирч байрлуулна.



Зураг 9. Хулганаар дарж шаардлагатай байрлалд чирч байрлуулна.

Мэдээлэл: Чиглэл хариуцсан бүтцийн нэгж нь шинэ барааны хүсэлт дэх техникийн үзүүлэлтийн статик төлөвтэй үзүүлэлтүүдийг захиалагчаас оруулсан гэж ойлгож болно.

- Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтаас хайлтын багажийг ашиглан өөрт шаардлагатай шүүлт, бүлэглэлтийг хийн ашиглах боломжтой бөгөөд өөрийн үүсгэсэн шүүлт, бүлэглэлтэд нэр өгч хадгалан тогтмол ашиглаж болно.




Зураг 10. Хайлтын багажийг ашиглан өөрт шаардлагатай шүүлт, бүлэглэлтийг хийж ашиглах

7. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтын баруун дээд өнцөгт байрлах тэмдэглэгээг дарж **Баталгаажуулалт** гэсэн сонголтыг хийснээр жагсаалтад тухайн барааны хүсэлтийг батлахаар хүлээгдэж буй бүтцийн нэгжийн мэдээллийг агуулсан багана нэмэгдэнэ.

Загвар	Бүтцийн нэгж	Үүсгэсэн	Approval state	Баталгаажуулалт	Бүртгэсэн огноо
OpenStage 15 T	Холбоо, мэдээллий...	М.Мөнхбаяр	Баталгаажуулсан ...	Үйлдвэрлэл, техник...	<input checked="" type="checkbox"/> Баталгаажуулалт <input checked="" type="checkbox"/> Бүртгэсэн огноо
RVVP 3x0.5	Холбоо, мэдээллий...	Д.Очирбат	Баталгаажуулсан ...	Үйлдвэрлэл, техник...	
INDGW-M2	Холбоо, мэдээллий...	П.Нацагдорж	Баталгаажуулсан ...	Чиглэл хариуцсан б...	2024-05-06 10:46:26
MX Vertical	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Started by Т.Баярм...		2024-05-06 11:38:30
ERGO K860 Wireless...	Холбоо, мэдээллий...	Т.Баярмагнай	Баталгаажуулсан Т...		2024-05-06 13:47:34


Зураг 11. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтад баталгаажуулалтын багана нэмэх

8. Хэрэглэгчийн ажиллах товчны тайлбар




Зураг 12. Хэрэглэгчийн ажиллах товчны тайлбар

9. UNSPSC ангилал нь 4 түвшинт 8 оронтой кодоор ангилсан бүлгүүдэд хуваагдсан байх бөгөөд UNSPSC ангиллыг ашиглахад зориулж Англи, Англи-Монгол, Англи-Орос, Англи-Монгол-Орос гэсэн сонголтыг дэлхийн бөмбөрцгийн зураг дээр дарж тохируулан ашиглах боломжтой.



Зураг 13. UNSPSC ангиллыг хэл сонгож харах

Өөрийн бүртгэх барааны ангиллыг олохын тулд ангиллын жагсаалтад хайлтыг орос, монгол, англи хэлээр хийх боломжийг бүрдүүлсэн. Хэрэглэгч өөрийн бүртгэх барааг тодорхойлох түлхүүр үгээр хайлт хийх нь оновчтой юм.



Зураг 14. UNSPSC ангилалд хайлт хийх

Мэдээлэл: Мөн demo-odoo.erdenetmc.mn домэйн хаягаар орж олон улсад хэрэглэгдэж буй UNSPSC ангиллыг ашиглан үүсгэсэн барааны каталог, барааны техникийн үзүүлэлтийн жишигээг харах боломжтой.

Сургалт, дэмжлэгийн баг